



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А-215

Улаанбаатар хот

Төсөл сонгон шалгаруулах хорооны
бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дугаар тушаалаар баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.1, 6.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хороо болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А-56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ч.УЛААН

00000600

Хүнс, хөдөө аж ахуй,
хөнгөн үйлдвэрийн Сайдын
2019 оны 17 дугаар сарын 02-ны
өдрийн 17.205 дугаар тушаалын
хавсралт

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮН

Хорооны дарга:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршооны хөгжлийн бодлого зохицуулалтын газрын дарга Я.Эрдэнэсайхан

Хорооны гишүүд:

- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт Ц.Пүрэвхүү
- Санхүүгийн зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн У.Ганчимэг
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Дэд захирал Б.Нямжилсүрэн
- Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Н.Есүхэн
- Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл НҮТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Цэрэндаш
- Төслийн удирдлага хөгжлийн хүрээлэн ТББ-ын Тэргүүн Ц.Өнөржаргал

Нарийн бичгийн дарга:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн Зээлийн удирдлагын хэлтсийн дарга Д.Дашхүү